

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**МӨНХХАЙРХАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2020 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/27/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 70432545

цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<b>АОУС</b>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<b>УСНББОУС</b>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<b>ТТЗ</b>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<b>ТШЗ</b>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<b>БСШУСЯ</b>	<i>Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яам</i>
<b>ТӨХК</b>	<i>Төрийн өмчит хувьцаат компани</i>
<b>ИТХ</b>	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>
<b>БҮТЭЗ</b>	<i>Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл</i>
<b>ОНХС</b>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
<b>ХХОАТ</b>	<i>Хувь хүний орлогын албан татвар</i>
<b>ЗДТГ</b>	<i>Засаг даргын тамгын газар</i>

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3. Аудитын тайлан .....	14
3.1. Ерөнхий зүйл .....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	15
3.4. Материаллаг байдал .....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.9. Аудитын илрүүлэлт .....	18
Залруулсан алдаа .....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж .....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
4. Менежментийн захидал .....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21

## **1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ**

---



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав бас Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

**МӨНХХАЙРХАН СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.БАТЗАЯА ТАНАА**

2021.02.08 № 2/36  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурьдсан алдаа зөрчлийг эс тооцвол Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдээгүй тул хязгаарлалттай санал, дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил

021020157

гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### **Аудитын гол асуудал**

Өмнөх санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, хүнсний материал их хэмжээгээр нөөцөлсөн, Шилэн дансны хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээллээгүй, тайлант үеийн үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн зэрэг зөрчлүүд "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "оршин байх", "толилуулга ба тодруулга", "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>77,932,268.15</u>	<u>124,044,238.65</u>
33	<b>АВЛАГА</b>	378,787.15	450,540.15
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	378,787.15	450,540.15
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	50,000,000
3471	<b>Урьдчилгаа тооцоо</b>	-	50,000,000
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	50,000,000
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	77,553,481	73,593,698.50
351	<b>Түүхий эд материал</b>	257,065	1,269,045
35130	Эм боох материал	257,065	1,269,045
354	<b>Хангамжийн материал</b>	77,296,416	72,324,653.50
35410	Бичиг хэргийн материал	816,500	678,150
35420	Аж ахуйн материал	1,718,284	2,520,284
35440	Түлш, шатах тослох материал	6,740,915	
35450	Барилгын засварын материал	48,000	814,000
35460	Хүнсний материал	8,967,400	13,196,150
35470	Бусад хангамжийн материал	59,005,317.00	55,116,069.50
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>1,226,899,846.53</u>	<u>1,200,700,567.90</u>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,226,899,846.53	1,200,700,567.90
392	<b>Биет хөрөнгө</b>	1,181,292,846.53	1,155,182,817.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,114,330,679	1,114,330,679
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38,551,164.36)	(77,479,517.39)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,483,500	16,483,500
39204	Хуримтлагдсан элэгдэл	(16,483,500)	(16,483,500)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	140,440,973	146,814,677
39206	Хуримтлагдсан элэгдэл	(125,698,522.67)	(133,577,900.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	101,600,239	101,815,415
39208	Хуримтлагдсан элэгдэл	(71,176,973.88)	(70,223,540.66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	45,598,355.00	58,214,255.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,091,784.56)	(16,107,969.12)
39217	Ном	22,841,046	31,396,719.22
393	<b>Биет бус хөрөнгө</b>	45,607,000	45,517,750
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(89,250)
39303	Бусад биет бус хөрөнгө	45,607,000	45,607,000
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<u>1,304,832,114.68</u>	<u>1,324,744,806.55</u>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<u>4,416,638</u>	<u>2,384,008</u>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4,416,638	2,384,008
413	<b>Өглөг</b>	4,416,638	2,384,008
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,635,208
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,416,638	-
4136	<b>Бусад өглөг</b>	-	748,800

41361	Байгууллагад төлөх өглөг	-	748,800
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<u>1,300,415,476.68</u>	<u>1,322,360,798.55</u>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,300,415,476.68	1,322,360,798.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	782,392,204	782,392,204
51101	Өмч: - төрийн	782,392,204	782,392,204
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(393,406,516.32)	(371,188,380.55)
51210	Өмнөх үеийн үр дүн	(393,406,516.32)	(392,866,847.73)
51220	Тайлант үеийн үр дүн	-	21,678,467.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	911,429,789	911,156,975.10
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<u>1,304,832,114.68</u>	<u>1,324,744,806.55</u>

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	706,691,170	962,311,044.72
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	663,828,800	871,914,844.72
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	537,000	40,454,344.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	537,000	37,994,344.72
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000	400,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	137,000	37,594,344.72
120009	Бусад орлого	-	2,460,000
123	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	663,291,800	831,460,500
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	663,291,800	819,294,600
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	-	12,165,900
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	42,862,370	90,396,200
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14,827,170	62,496,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000	60,000,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,958,000	2,496,000
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	28,035,200	27,900,200
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,035,200	27,900,200
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	761,792,005.65	936,024,274.84
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	761,792,005.65	935,538,261.79
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	745,518,205.65	890,682,819.03
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	533,129,447	659,619,781
210101	Үндсэн цалин	510,053,021	463,368,158
210102	Нэмэгдэл	22,768,586	137,276,572
210104	Урамшуулал	307,840	58,975,051

2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	66,224,880.85	82,865,305.93
210201	Тэтгэврийн даатгал	45,451,173.45	57,178,255.19
210202	Тэтгэмжийн даатгал	5,334,575.35	6,602,597.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,261,983.48	5,282,078.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,065,495.87	1,254,761.33
210205	Эрүүл мэндийн даатгал	10,111,652.70	12,547,613.36
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,649,938	23,918,604
210301	Гэрэл, цахилгаан	5,345,138	4,971,569
210302	Түлш, халаалт	19,957,800	18,630,115
210303	Цэвэр, бохир ус	347,000	316,920
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,553,019	16,271,346.66
210401	Бичиг хэрэг	736,400	844,300
210402	Тээвэр, шатахуун	1,806,319	1,955,400
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	508,300	605,900
210404	Ном, хэвлэл	-	24,000
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,000.00	160,100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	248,500	12,537,646.66
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	220,500	144,000
2105	<b>Нормативт зардал</b>	33,741,895	18,977,556
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	218,995	1,349,220
210502	Хоол, хүнс	31,123,400	15,421,030
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,399,500	2,207,306
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,003,060	13,695,050
210602	Тавилга	-	150,000
210604	Урсгал засвар	2,281,300	13,545,050
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	544,300	327,000
210702	Дотоод албан томилолт	544,300	327,000
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	392,000	2,852,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,460,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000	392,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	79,279,665.80	72,156,175.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,720,770	329,445
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,991,195	3,903,950
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,567,701	67,922,780.44
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16,273,800	44,855,442.76
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,273,800	9,936,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,273,800	9,936,900.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	33,987,242.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	33,987,242.76

2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	931,300
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	931,300
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	486,013.05
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	486,013.05
222001	Тоног төхөөрөмж	-	486,013.05
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<u>(55,100,835.65)</u>	<u>26,286,769.88</u>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	4,388,143.70
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	4,388,143.70
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(4,388,143.70)
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<u>(55,100,835.65)</u>	<u>21,898,626.18</u>

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<u>706,554,170</u>	<u>912,550,800.00</u>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	663,691,800	822,154,600.00
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	400,000	2,860,000
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	400,000	400,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000	400,000
120009	Бусад орлого	-	2,460,000
123	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	663,291,800	819,294,600
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	663,291,800	819,294,600
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	42,862,370	90,396,200
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14,827,170	62,496,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000	60,000,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,369,170	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,958,000	2,496,000
131106	Төсвийн урамшуулал		
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	28,035,200	27,900,200
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,035,200	27,900,200
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<u>705,054,170</u>	<u>862,550,800</u>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	705,054,170	862,550,800
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	688,826,570	817,695,357.24
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	533,012,800	659,694,054
210101	Үндсэн цалин	379,601,100	447,197,024
210102	Нэмэгдэл	97,420,600	160,388,746
210104	Урамшуулал	38,305,100	52,108,284
210105	Гэрээт ажлын хөлс	17,686,000	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	66,626,500	81,110,723.24

210201	Тэтгэврийн даатгал	45,306,000	56,777,577.39
210202	Тэтгэмжийн даатгал	5,330,100	6,115,832.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,264,100	4,899,817.87
210204	Ажилгүйдлийн даатгал	1,066,000	1,210,656.18
210205	Эрүүл мэндийн даатгал	10,660,300	12,106,839.08
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,275,900	23,971,980
210301	Гэрэл, цахилгаан	5,304,938	6,424,395
210302	Түлш, халаалт	21,647,762	17,227,585
210303	Цэвэр, бохир ус	323,200	320,000
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,780,900	7,162,400
210401	Бичиг хэрэг	503,000	396,600
210402	Тээвэр, шатахуун	1,562,700	1,720,900
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	516,900	548,000
210404	Ном, хэвлэл	312,500	352,500
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	134,100	190,900
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	751,700	3,953,500
2105	<b>Нормативт зардал</b>	37,334,400	23,271,880
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	255,100	2,532,100
210502	Хоол, хүнс	35,459,000	19,493,780
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,620,300	1,246,000
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,130,976	15,492,920
210602	Тавилга	-	1,450,000
210604	Урсгал засвар	2,130,976	14,042,920
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	268,220	257,000
210702	Дотоод албан томилолт	268,220	257,000
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,147,840	2,852,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,964,240	2,460,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	183,600	392,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15,249,034	3,882,400
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,941,700	400,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,307,334	3,482,400
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16,227,600	44,855,442.76
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,227,600	9,936,900
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,227,600	9,936,900
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	33,987,242.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	33,987,242.76
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	931,300
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	931,300
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<u>1,500,000</u>	<u>50,000,000</u>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	1,500,000	50,000,000
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	1,500,000	50,000,000
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,500,000	50,000,000

220001	Барилга байгууламж	-	50,000,000
223001	Бусад хөрөнгө	1,500,000	-
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b> (6)=(4)-(5)	<b>(1,500,000)</b>	<b>(50,000,000)</b>

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	782,392,204	911,429,789	(393,406,516.32)	1,300,415,476.68
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	782,392,204	911,429,789	(393,406,516.32)	1,300,415,476.68
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	782,392,204	911,429,789	(393,406,516.32)	1,300,415,476.68
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	782,392,204	911,429,789	(393,406,516.32)	1,300,415,476.68
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	539,668.59	539,668.59
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	782,392,204	911,429,789	(392,866,847.73)	1,300,955,145.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(272,813.90)	-	(272,813.90)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	21,678,467.18	21,678,467.18
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		911,156,975.10	(371,188,380.55)	539,968,594.55

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	691,727,200	691,723,800	847,594,900	812,676,257.24
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	691,727,200	691,723,800	847,594,900	812,676,257.24
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	675,453,400	675,496,200	833,813,100	802,739,357.24
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	533,012,800	533,012,800	667,912,400	659,694,054
210101	Үндсэн цалин	379,601,100	379,601,100	452,701,900	447,197,024
210102	Нэмэгдэл	97,420,600	97,420,600	162,395,300	160,388,746
210104	Урамшуулал	38,305,100	38,305,100	52,815,200	52,108,284
210105	Гэрээт ажлын хөлс	17,686,000	17,686,000	-	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	66,626,500	66,626,500	90,168,100	81,110,723.24
210201	Тэтгэврийн даатгал	45,306,000	45,306,000	63,451,600	56,777,577.39
210202	Тэтгэмжийн даатгал	5,330,100	5,330,100	6,679,100	6,115,832.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,264,100	4,264,100	5,343,300	4,899,817.87
210204	Ажилгүйдлийн даатгал	1,066,000	1,066,000	1,335,800	1,210,656.18
210205	Эрүүл мэндийн даатгал	10,660,300	10,660,300	13,358,300	12,106,839.08
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,272,700	27,272,700	23,968,900	23,971,980
210301	Гэрэл, цахилгаан	5,295,300	5,304,938	5,824,800	6,424,395

210302	Түлш, халаалт	21,657,400	21,647,762	17,824,100	17,227,585
210303	Цэвэр, бохир ус	320,000	320,000	320,000	320,000
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,798,500	3,686,730	7,162,400	7,162,400
210401	Бичиг хэрэг	396,600	503,000	396,600	396,600
210402	Тээвэр, шатахуун	1,339,200	1,468,530	1,720,900	1,720,900
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	565,800	516,900	548,000	548,000
210404	Ном, хэвлэл	352,500	312,500	352,500	352,500
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	190,900	134,100	190,900	190,900
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	953,500	751,700	3,953,500	3,953,500
2105	<b>Нормативт зардал</b>	36,966,600	37,216,400	36,138,600	23,271,880
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	255,300	255,100	2,532,100	2,532,100
210502	Хоол, хүнс	35,465,300	35,459,000	32,360,500	19,493,780
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,246,000	1,502,300	1,246,000	1,246,000
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	931,300	931,300	3,931,300	2,996,920
210604	Урсгал засвар	931,300	931,300	3,931,300	2,996,920
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	257,000	268,220	257,000	257,000
210702	Дотоод албан томилолт	257,000	268,220	257,000	257,000
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	183,600	183,600	392,000	392,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	183,600	183,600	392,000	392,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,404,400	6,297,950	3,882,400	3,882,400
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,458,700	1,412,900	400,000	400,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,945,700	4,885,050	3,482,400	3,482,400
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16,273,800	16,227,600	13,781,800	9,936,900
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,273,800	16,227,600	13,781,800	9,936,900
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,273,800	16,227,600	13,781,800	9,936,900
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	692,127,000	691,727,000	847,594,900	812,676,257
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	663,691,800	663,291,800	819,294,700	784,376,057.24
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	663,691,800	663,291,800	819,294,700	784,376,057.24
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	28,035,200	28,035,200	27,900,200	27,900,200
132001	Орон нутгийн төсвөөс	28,035,200	28,035,200	27,900,200	27,900,200
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	400,000	400,000	400,000	400,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000	400,000	400,000	400,000
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	53	53	56	56
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	32	32	32	32
620003	Үйлчлэх ажилтан	16	16	16	16
620004	Гэрээт ажилтан	4	4	7	7
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	449	449	443	435

630	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	449	449	443	435
630001	Төрийн өмчит ЕБС	1	1	1	1
630002	Хувийн ЕБС	1	1	1	1
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	46.00	46.00	58.00	56.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1	1	1	1
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	30	30	30	30
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	8	8	20	18
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)				
650010	Гэрээт ажилтан	7	7	7	7

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	14,827,170	62,496,000
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	13,327,170	12,496,000
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	13,327,170	12,496,000
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	94,170	-
210402	Тээвэр, шатахуун	94,170	
2105	<b>Нормативт зардал</b>	118,000	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	118,000	
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,199,676	12,496,000
210602	Тавилга	-	1,450,000
210604	Урсгал засвар	1,199,676	11,046,000
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,964,240	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,964,240	
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,951,084	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,528,800	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,422,284	
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	1,500,000	50,000,000
2200	Дотоод эх үүсвэрээр	1,500,000	50,000,000
220001	Барилга байгууламж	-	50,000,000
223001	Бусад хөрөнгө	1,500,000	
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	12,417,170	62,496,000
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,417,170	62,496,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000	60,000,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,369,170	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,548,000	2,496,000

### 3. АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг сургуулийн захирал Б.Бат Заяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын зарцуулалт, ур чадварын болон улирлын мөнгөн урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоолол, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Л.Галбадрах гүйцэтгэхээр хуваарилагдсан боловч эрүүл мэндийн шалтгаанаас эмнэлэгт хэвтсэн тул өөрчлөлт оруулж 2021 оны 02 дугаар сарын 06-наас 2021 оны 02 дугаар сарын 08-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хариуцаж хэрэгжүүлэв.

#### 3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургууль нь “Хүүхэд нэг бүрийн хөгжлийг эрхэмлэн бүтээлч сэтгэлгээтэй, бие даан суралцах чадвартай, эх хэлээ сайн эзэмшсэн суралцагсдын оролцоог чухалчилж, ажилдаа чин сэтгэлээсээ хандаж, ая тухтай орчинд чанартай үйлчилгээг үзүүлэх” гэсэн зорилго, зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын үндсэн зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлох,
- Иргэн тодорхой хугацаанд мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдах, бие даан суралцах замаар боловсрол, мэргэшлийн ур чадвараа байнга дээшлүүлэх,
- Үндсэн хуульд заасны дагуу төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгох,
- Боловсролын байгууллагын тогтолцоо нь сургалтын, эрдэм шинжилгээ, арга зүйн боловсролын үнэлгээний, мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн болон бусад байгууллагаас бүрдэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*

- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдэж нийт 1401.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1401.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт бичигдэж, аймгийн Төрийн сангаас өдөр тутмын хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлаас 812955.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 8129.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 963511.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 9635.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19912.7 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өр, төлбөр, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	378.8	50,450.5	50,071.7
Бараа материал	77,553.5	73,593.7	(3,959.8)
Үндсэн хөрөнгө	1,226,899.8	1,200,700.6	(26,199.2)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,304,832.1</b>	<b>1,324,744.8</b>	<b>19,912.7</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>4,416.6</b>	<b>2,384.0</b>	<b>(2,032.6)</b>
Цэвэр хөрөнгө, өмч	1,300,415.5	1,322,360.8	21,945.3
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,304,832.1</b>	<b>1,324,744.8</b>	<b>19,912.7</b>

Авлага дансны үлдэгдэл 50450.5 мянган төгрөг болж 50071.7 мянган төгрөгөөр өссөн шалтгаан нь цалин хөлстэй холбоотой авлага нэмэгдсэн, хөл бөмбөгийн талбай

байгуулахтай холбоотой хөрөнгө бэлтгэх урьдчилгаа олгосонтой холбоотой нэмэгдсэн, санхүүгийн тайлан дахь авлага нь бүрэн барагдах боломжтой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 73593.7 мянган төгрөг болж 3959.8 мянган төгрөгөөр буурсан нь сумын ИТХ-ын А/13 тоот тогтоолоор БҮТЭЗ-ийг данс бүртгэлээс хассанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1514662.2 мянган төгрөг болж 27760.4 мянган төгрөгөөр өссөн нь БСШУСЯам, сумын ОНХС-аас тоног төхөөрөмж, тавилга эд хогшим, ном сурах бичгийг үнэ төлбөргүй шилжүүлэн өгснөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь БСШУСЯамны хөрөнгө оруулалтаар ном, компьютер тоног төхөөрөмж, эцэг эхчүүдийн хандив, сумын ОНХС-ийн хичээлийн байр, дотуур байрны хяналтын камер, зэрэг хөрөнгийг хандив, үнэ төлбөргүйгээр 46331.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийг сумын ИТХ-ын А/13 тоот тогтоолоор 20981.4 мянган төгрөг данс бүртгэлээс акталж хасагдсан, биет бус хөрөнгөтэй холбоотой өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2384.0 мянган төгрөг болж 2032.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны түлш халаалтын зардлын өр төлбөрийг бүрэн барагдуулсан, өр төлбөр дансны үлдэгдэлд 2384.0 мянган төгрөгийн өр төлбөр байгаагаас цалингаас суутгасан ХХОАТ-ын болон өмчийн санд төвлөрүүлэх түрээсийн орлогын 30 хувийг төвлөрүүлээгүйтэй холбоотой бүрэн барагдах боломжтой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1322360.8 мянган төгрөг болж 21945.3 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх үеийн үр дүн данс руу залруулах бичилт хийгдсэн, тайлант онд 21678.4 мянган төгрөгийн ашигтай гарсан зэргээс шалтгаалж байна.

Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 255619.8 мянган төгрөгөөр буюу 36.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй 37457.3 мянган төгрөгийн орлогыг хүлээн авсан, тусгай зориулалтын санхүүжилт 168168.7 мянган төгрөгөөс өссөнөөс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 174232.3 мянган төгрөгөөр буюу 22.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, шимтгэлийн зардал 143130.7, хангамж бараа материалын зардал 12718.3, эд хогшил, урсгал засварын зардал 10692.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 2460.0, хөрөнгийн зардал 486.0, орон нутгийн төсөвт 34918.5 мянган төгрөгөөр тус тус өссөн, тогтмол зардал 1731.3, нормативт зардал 14764.3, урсгал шилжүүлэг 6336.9, бараа үйлчилгээний бусад зардал 7123.5, дотоод томилолтын зардал 217.3 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 539.7 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь өмнөх онд шимтгэлийн авлага, акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлтэй холбоотой залруулга бичсэнтэй холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 747149.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 747149.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 847194.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 847194.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 400.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 847194.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 400.0 мянган төгрөг, нийт 847594.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 812676.3 мянган төгрөгийг зарцуулж 34918.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 812676.3 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 17275.7, нормативт зардал 12866.7, эд хогшил, урсгал засварын зардал 934.4, урсгал шилжүүлэг 3844.9 мянган төгрөгөөр дутуу, тогтмол зардлыг 3.1 мянган төгрөгөөр илүү зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээ 33987.2 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой ерөнхий боловсролын сургуулиуд хичээллээгүйгээс шалтгаалсан байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,881.1
81801	Үдийн цай хөтөлбөр	3,844.8
81806	Дотуур байрны үйлчилгээ	16,689.7
80305	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	1,205.1
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	6,366.5
	<b>ДҮН</b>	<b>33,987.2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын ОНХС-аас сургуулийн сургуулийн барилгын дээврийн засварт 10000.0, хөл бөмбөгийн талбай байгуулах зардалд 50000.0, Мобиком, Юнител ХХК-аас түрээсийн орлогоор 2496.0, сурах бичгийн түрээсийн орлого 2460.0 мянган төгрөг нийт 64956.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс сургуулийн дээврийн засварт 9447.2, сурах бичгийн түрээсийн орлогыг БСШУСЯаманд 2460.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн, үндсэн хөрөнгө худалдан авахад 1949.8, урсгал засварт 1099.0, хөл бөмбөгийн талбай шинээр байгуулахад 50000.0 нийт 28214.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 13120.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 134 мэдээлэл, 13 мэдээллийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлага, 22723.7 мянган төгрөгийн 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 119 мэдээлэл, хугацаа хоцроосон 11 мэдээлэл, 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээллээс эрсдэлтэй гэж үзсэн гүйлгээг хянахад сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар ЗДТГазар болон ОНХС-аас олгосон орлогын ажил гүйлгээний мэдээллийг мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1380.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 19314.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	-	-	-	-	-	-	
Албан шаардлага	1	1,380	-	-	1	1,380	
Зөвлөмж	4	19,314.8	2		2	19,314.8	50
Нийт дүн	5	20,694.8	2	-	3	20,694.8	

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 45474.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5745.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 396.3 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож 39333.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материалын үлдэгдлийг 579.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
2. Мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого, түрээсийн сурах бичгийн орлогыг 3391.3 мянган төгрөгөөр холбогдох дансны бичилтийг буруу тусгасан,
3. Нийгмийн даатгалын шимтгэлийн өмнөх оны 266.9 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй,
4. Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлыг 89.3 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,

5. Акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг 272.8 мянган төгрөгөөр бууруулаагүй,
6. Өмнөх үеийн үр дүнг 539.7 мянган төгрөгөөр залруулга бичилтийг орхигдуулсан,
7. Тайлант оны үр дүнг 605.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасангай холбоотой нийт 5745.2 мянган төгрөгийн залруулгыг аудитын явцад хийгдлээ.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулж 5745.2 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 396.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 396.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Цалингийн урьдчилгаа олгоод суутгаагүй, авлагаар тусгаагүй, захиралд ур чадварын нэмэгдлийг зөрүүтэй тооцож 396.4 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, аудитын “үнэн зөв байдал”, “бодитой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичих

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 39333.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар сургуулийн хичээлийн байрны дээврийн засварт 10000.0, хөл бөмбөгийн талбай байгуулахтай холбоотой 50000.0 мянган төгрөгийг зарцуулсан нь дараагийн аудитаар шалгах асуудал байна.

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **1. Бараа материалын данстай холбоотой асуудал**

- 1.1. Илрүүлэлт: Тайлант оны эцэст 10944.2 мянган төгрөгийн буюу 2190.6 кг махыг их хэмжээгээр нөөцөлсөн, ТШЗ-ын тушаал шийдвэргүй хэдэн хүүхдэд хэчнээн нэр төрлийн хүнсний материал олгосныг нотлох баримтгүй, оны эцэст хүнсний материалд тооллого хийгдсэн боловч үлдэгдлийг баталгаажуулаагүй балансад тусгасан үлдэгдэл тооцоогоор үлдэгдэл зөрүүтэй, 2020 онд 4131 хүүхэд өдөрт 962.5 кг мах махан бүтээгдэхүүн зарцуулсан 1 хүүхэд өдөрт зарцуулах норм мөрдөөгүтэй 11692.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
- 1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх, амархан муудах

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, ЭМЯам, БСШУСайдын хамтарсан тушаалаар баталсан норм нормативыг мөрдөн ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

## **2. Ур чадварын болон улирлын мөнгөн урамшуулал олгохтой холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт: Байгууллагын ажилчдын ажлын үр дүнг тооцож хамт олноор хэлэлцүүлэн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгоогүй тайланд онд 19844.5, ур чадварын нэмэгдлийг 11 сард 7014.6 мянган төгрөг нийт 26859.1 мянган төгрөгийг ажлын үр дүнг тооцоогүй хавтгайруулан олгосон зөрчил дутагдал байна.

2.2. Эрсдэл: Ажлын үр дүн буурах, хариуцлага алдагдах

2.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3 дугаар хавсралтын 1.2-д “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно”, 2.4-д “Төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журамд заасан нөхцөл, шалгуурыг баримтална”, 2.5-д “2.5. Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно”, Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 3-д “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын цалингийн 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

## **3. Зардлын данстай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог хянахад тайланд онд 782.1 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн, байгууллагын шимтгэлийн тайлангаар өр төлбөргүй, НДХэлтэстэй хийсэн тооцоогоор үлдэгдэлгүйгээр тооцоо нийлсэн байна.

3.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, өглөг, авлага дутуу тусгах

3.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтыг мөрдөн тооцоог дахин хийж баталгаажуулах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

## **4. Шилэн данстай холбоотой асуудал**

4.1. Илрүүлэлт: Шилэн дансны хуульд заасны дагуу сар бүрийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого буюу сар бүрийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн дансанд сумын ЗДТГ болон ОНХС-аас шилжүүлсэн орлого, зарлагын ажил гүйлгээ, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан, батлагдсан төсөвт орсон өөрчлөлтийн мэдээллийг байршуулаагүй байна.

**4.2. Эрсдэл:** Мэдээллийг ил тод нээлттэй мэдээлэхгүй байх,

**4.3. Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.5.4-д “улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр” мэдээлэх гэсэн заалтуудыг мөрдөн холбогдох мэдээллийг тухай бүрд мэдээлж хэвших.

**4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	<b>Мөнххайрхан сумын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			XOA-2021/27/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Мөнххайрхан сумын сургууль</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цалингийн урьдчилгаа олгоод суутгаагүй, авлагаар тусгаагүй, захиралд ур чадварын нэмэгдлийг зөрүүтэй тооцож олгосон	396.4	Төлбөрийн акт	Сургуулийн захирал, нягтлан бодогч	Б.Бат Заяа, Л.Минжмаа
2	Бараа материалын зарлага илүү гаргаж материалын үлдэгдэл хасах тэмдэгтэй тусгасан	579.8	Залруулга		
3	Мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн хөрөнгө болон түрээсийн номын орлогыг бүртгэхдээ холбогдох дансны бичилтийг буруу илэрхийлсэн	3391.3	Залруулга хийх		
4	Өмнөх онд НДШ-тэй холбоотой авлагыг бүртгээгүй холбогдох дансны бичилтийг хийгээгүй, тайлант онд шимтгэлийн тооцоогоор өглөг тусгаагүй	266.8	Залруулга хийх		
5	Тайлант оны үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн, өмнөх оны авлага, дахин үнэлгээний зөрүү өмнөх үр дүн рүү залруулаагүй орхигдуулсан	1145.2	Залруулга хийх		
6	Тайлант оны хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн зардлыг зөрүүтэй, 2010 онд дахин үнэлэгдсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасахдаа дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулах бичилтийг орхигдуулсан,	362.1	Залруулга хийх		

7	Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог хянахад тайланд онд 782.1 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн, байгууллагын шимтгэлийн тайлангаар өр төлбөргүй, НДХэлтэстэй хийсэн тооцоогоор үлдэгдэлгүйгээр тооцоо нийлсэн	782.1	Зөвлөмж өгөх		
8	Ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг олгохдоо ажлын гүйцэтгэлд тулгуурлан олгоогүй хавтгайруулан олгосон	26859.1	Зөвлөмж өгөх		
9	ТШЗ-ын тушаал шийдвэргүй хэдэн хүүхэд хэчнээн нэр төрлийн хүнсний материал олгосныг нотлох баримтгүй, тайлант оны эцэст хүнсний материалд тооллого хийгдсэн боловч үлдэгдлийг баталгаажуулаагүй балансад тусгасан үлдэгдэл тооцоогоор үлдэгдэл зөрүүтэй, 2020 онд 4131 хүүхэд өдөрт 962.5 кг мах махан бүтээгдэхүүн зарцуулсан 1 хүүхэд өдөрт зарцуулах норм мөрдөөгүй, 2020 оны эцэст 10944.2 мянган төгрөгийн махыг их хэмжээгээр нөөцөлсөн	11692.1	Зөвлөмж өгөх		
10	Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан, 5 сая төгрөгөөс дээш орлого буюу санхүүжилтийн ажил гүйлгээ, нэмэлт санхүүжилтийн орлого, зарлагын ажил гүйлгээг мэдээлээгүй	0	Зөвлөмж өгөх		
<b>ДҮН</b>		45474.9			

### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР